

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-23

---

1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	3
2. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	3-23

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
04 дүгээр сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 32 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Ц.Идэрбат, Ц.Туваан;  
Чөлөөтэй: Х.Болорчулуун.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл** /Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Батжаргал:** “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд** /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор Б.Баасансүх, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн зөвлөх Б.Мягдадаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ж.Батжаргал, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Г.Мөнхцэцэг, Н.Ганибал, Г.Ганболд, Ц.Цэрэнпунцаг, Г.Дамдинням нар үг хэлэв.

**Ж.Батжаргал:** Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 15 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 11 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим,  
10 цаг 32 минут

### БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Батжаргал:** Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанд Батжаргал, Аубакир, Саранчимэг, Ганболд, Ганибал, Дамдинням, Наранбаатар, Тэмүүлэн, Цогтгэрэл, Цэрэнпунцаг гишүүд хүрэлцэн ирж, хуралдаан эхлэх ирц бүрдсэн байна. Ийм учраас 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааныг эхлүүлж байна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэгдэхээр орж ирж байна.

1 дүгээр, Байнгын хорооны тогтоолын төсөл. 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай,

2 дахь нь, Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд. Улсын Их Хурлын 38 гишүүн санаачлан өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх тухай асуудал.

Хэлэлцэх асуудлаас асууж тодруулах зүйл байна уу, гишүүдэд. Байхгүй байна.

Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын дарга 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 42 дугаар захирамжийг батлан гаргасан.

Энэ захирамжийн дагуу **Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 4 дүгээр сард хэлэлцэх асуудлынхаа цаглавар, тогтоолын төслөө боловсруулж та бүгддээ хүргүүлсэн байгаа.**

Байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавраас асууж тодруулах саналтай гишүүд байна уу? Алга байна.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 80 хувийн саналаар тогтоол цаглавар дэмжигдэж батлагдлаа.

Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

10.35 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

**Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг, хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.**

Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд танилцуулна. Ганболд гишүүний микрофоныг өгөөрэй.

**Г.Ганболд:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүнээс Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулж, 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Уг хуулийн төслийг санаачлан боловсруулах дараах шаардлагууд байлаа. Үүнд:

1.Эдийн засгийн анхдагч уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах нь дэлхийн бусад орноос ялгарах, ондооших, өвөг дээдсийнхээ өв соёлоо хадгалж хойч үедээ өвлүүлэх, эдийн засгийн бусад салбарын хөгжлийн тулгуур, хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэс юм.

2.Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч ган, зуд зэрэг байгалийн эрсдэлт болон давагдашгүй хүчин зүйлийн давтамж ойртсон манай улсын нийт газар нутгийн 76,9 % нь ямар нэгэн байдлаар цөлжилтөд нэрвэгдээд байгаа нь бэлчээрийн аж ахуйн салбар эрсдэлт байдалтай нүүр тулаад байна.

3.Бэлчээрийн даац хэтэрч, цөлжилт доройтол хүчтэй явагдахын зэрэгцээ мал нь тэжээлийн архаг дутагдалд орсноос давжаарч ашиг шим, үнэ цэн буурч байна.

ХХААХҮЯ-ны 2018 оны мэдээгээр 2004-2014 онд хонины амьдын жин 1-2 кг, үхрийнх 30 кг-аар буурсан. 1990-2016 онд богийн гулуузны жин 13,9 хувь буурсан баримт байна. Өөрөөр хэлбэл манай улсын эдийн засгийн гол салбарын нэг болсон мал аж ахуйн маань бүтээмж буурч, үнэ цэн муутай, улсын эдийн засагт оруулах хувь нэмэр улам бүр буурсаар байгааг та бид харж байгаа билээ.

Иймд Монгол орны газар зүй, уур амьсгал, бэлчээрийн мал аж ахуйн онцлогоос хамааран Монголчууд эрт дээр үеэс айл саахалтаараа хүч хөдөлмөрөө

нэгтгэн, байгаль цаг уурын хүндрэл бэрхшээлийг даван туулж ирсэн уламжлалыг өнөөгийн байгаль цаг уур, нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдуулж, малчдын өөрсдийн үүсгэл санаачилга, оролцоонд тулгуурлан хамтын удирдлага, хариуцлагын үндсэн дээр байгалийн нөөц, бэлчээрийг доройтлоос хамгаалах, зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх нь өнөөдөр бид нар зайлиггүй шийдвэрлэх ёстой хойшлуулиггүй чухал асуудал болж тулгараад байна.

Үүнийг шийдэхийн тулд хууль зүйн хувьд малчдын хамтын зохион байгуулалт, өөрсдийн үүсгэл санаачилгын байгууллагын эрх зүйн байдлыг төрөөс тодорхой зохих нь ач холбогдолтой гэж үзэж, уг хуулийн төслийг санаачлан Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Малчин өрхийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл 5 бүлэг, 34 зүйлтэй. Зэргэлдээ нутагладаг буюу нэг нутаг усны бэлчээрийг хамтран ажигладаг малчин өрхүүд нь газар нутгийн онцлог, бэлчээрийн нөхцөл байдлаас хамаарч 20-оос доошгүй өрх нэгдэж, малчин өрхийн анхдагч холбоог байгуулахаар төсөлд тусгасан. Анхдагч холбоо нь гишүүдийнхээ боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрт төрийн үйлчилгээг хүргэх, гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөц зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын эрүүл мэнд, үржил, ашиг шимийг дээшлүүлэх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх гэсэн 4 үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд гишүүн малчин өрхүүдийг зохион байгуулж оролцоно.

Малчдын сайн дурын энэ холбоо нь ашигийн бус бөгөөд зөвхөн хөдөлмөрөөр орших замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн суурь болсон бэлчээр, нутгаа хамгаалах, нөхөн сэргээхэд

дэмжлэг үзүүлэх юм. Харин мал аж ахуйн үйлдвэрлэлийг буюу ашигийн төлөө үйл ажиллагааг малчдын өөрсдийнх нь үүсгэн байгуулсан хоршоо бусад аж ахуйн нэгжсийн хэлбэрээр эхлэх боломж нээлттэй байх болно. Өөрөөр хэлбэл анхдагч холбоо нь гишүүдийнхээ мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хоршоо, аж ахуйн нэгж хэлбэрээр эхлэх, Хөдөө аж ахуйн бирж зэрэг этгээдэд борлуулахад нь зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, хоршоог хөгжүүлэхэд хөшүүрэг түлхэц болохоос гадна малчдын орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Малчин өрхийн анхдагч холбоо нь суурь нэгж болохын хувьд бүх гишүүдийн хурал, түүний чөлөөт цагт тэргүүлэгчид, ахлагч гэсэн удирдлагын бүтэцтэй байх бөгөөд эдгээр институцийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх, үүрэг, түүнчлэн гишүүнчлэлийн талаар төсөлд тусгайлан зохицуулсан. Бэлчээрийг сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр хуваарьтай ашиглаж, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах ажлыг анхдагч холбоо хариуцахаар төсөлд тусгалаа.

Сумын малчин өрхийн холбоо нь тухайн сумдад үйл ажиллагаа явуулж байгаа анхдагч холбоодын гишүүнчлэлтэй байх ба тэдгээр анхдагч холбооноос ахлах холбооны ахлагч нараас бүрдэнэ. Аймгийн малчин өрхийн холбоо нь сумын малчин өрхийн холбоо бүрээс сонгогдсон 2 гишүүний төлөөллөөс бүрдэхээр улсын хэмжээнд малчин өрхийн нэгдсэн холбоо ажиллах. Уг холбоо нь аймгийн малчин өрхийн холбооны дарга нараас бүрдэхээр төсөлд тусгалаа.

Сум, аймгийн болон малчин өрхийн холбоо, нэгдсэн холбоо, доод шатын холбоодын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулалтаар хангах, төрийн бодлого тухайн шатын бодлогын баримт бичиг үйл ажиллагаанд малчин өрх

холбооны эрх ашиг сонирхлыг илэрхийлэх, саналаа өгөх нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх юм. Түүнчлэн холбооны санхүүжилт нь гишүүнчлэлийн хураамж, хууль тогтоомжийн дагуу олгосон санхүүжилт, хуульд заасан үйл ажиллагаа, эрхэлж олсон орлого, гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж, хууль тогтоомж, дүрэмд заасан бусад эх үүсвэрээс бүрдэх ба үүнийг дээр дурдсан 4 үндсэн чиглэлийн болон дүрэмд заасан бусад үйл ажиллагаанд зарцуулахаар тусгав.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг 12 хууль, Улсын Их Хурлын 2 тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслүүдийг боловсруулсан.

Та бүхэнд хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг хүргүүлсэн байгаа. Хуулийн төслийн талаар 2024 оны 01 дүгээр сард салбарын судлаач, эрдэмтэд, ТББ-ын төлөөлөл, холбогдох мэргэжлийн болон төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Түүнээс гадна хуулийн төслийг санаачлагч гишүүд орон нутагт ажиллахдаа малчид, иргэдэд танилцуулж, санал бодлоо солилцсон болно.

Эрхэм гишүүд ээ, Орон нутагт цаг, зудын нэн хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөл байдал, манай улсын ХАА түүний дотор амиа аргацаах төдий саланги бутархай мал аж ахуйн салбарт бодлого тогтолцооны шинэчлэл зайлшгүй чухал байгааг батлан харуулж байна. Байгалийн бэрхшээл тулгарсны дараа араас нь арга хэмжээ авах бус малчдын өөрсдийн оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан бэлчээрээ хамгаалах, нөхөн сэргээх, малын ашиг

шим, үнэ цэнийг өсгөх, өвлийн бэлтгэлээ хамтын хүчээр сайтар хангадаг байх, малчдыг мэдлэгжүүлэх, сайн туршлагыг сурталчлах зэрэг чиглэлээр бодлогын арга хэмжээ авах шаардлагад тулгуурлаад байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх суурь гарц шийдэл нь Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төсөлд туссан гэж үзэж байна.

Малчин, мал, бэлчээр 3-ын харилцан шүтэлцээг хангаж, нүүдлийн соёл, иргэнийн дархлааг хамгаалж, өвийг ийнхүү хадгалснаар Монгол Улсын тусгаар тогтнол, хүнсний аюулгүй байдал, иргэдийн амь амьжиргаа, эрүүл мэндийг хамгаалахаас гадна газрын харилцааны шинэчлэл хоршоог хөгжүүлэх суурь ач холбогдолтой юм.

Иймд Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал, малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Ганболд гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Д.Лүндээжанцан Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх, Б.Баасансүх ХААИС-ийн ректор, Б.Мяхдадаг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн зөвлөх, С.Энхцэцэг Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүй дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх.

Хуулийн төслийн танилцуулга, хуулийн төслөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгье.

Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Ганибал гишүүн асуултаа асууя.

**Н.Ганибал:** Үгүй ээ, үгүй хэд хэдэн асуудал байна. Энэ яагаад нэгхэн холбоонд зориулаад хууль гаргаад байгаа юм бэ? Өнөөдөр чинь Монгол Улсад хоршооны тухай хууль, тэгээд бүх л энэ дотор байгаа асуудлууд чинь бүгд нээлттэй байгаа шүү дээ. Тэгээд зөвхөн нэг малчдын холбоонд зориулсан хууль гаргаад тэгээд сумын Засаг даргын оролцоо, аймгийн Засаг даргын оролцоотой доторхыг нь уншлаа л даа. Мэдээж өнөөдөр Монголын мал аж ахуйн салбарт тулгамдсан бүх асуудлуудыг дотор нь тусгасан. Түүнийх нь гарц гаргалгаа байхгүй. Холбоо гээд байгуулах юм байна. Ер нь бид нар яг энэ сүүлийн 33 жил энэ хоршоо, нөхөрлөл ингээд янз бүрийн л байдлаар л малчдыгаа хооронд нь хоршиж амьдрах энэ эрх зүйг хийх гэж, зураглал гаргах гэж нэлээдгүй оролдсон. Энэ бол жоохон захиргааны аргаар нэг ийм холбоо байгуулах гээд л байгаа л асуудал. Байна. Захиргааны аргаар. Энэ сумын Засаг даргын оролцоотой, аймгийн Засаг даргын оролцоотой, тэгээд цаашиаад тэр Мэргэжлийн нэгдсэн холбоодын тухай хууль гээд явж байгаа. Түүнтэй уялдах юм бол сайд, яамд нь доороо нэг холбоотой. Тэгээд ийм нэг юм угсрагдсан л нэг юм харагдаад байна.

Ер нь хоршоо, холбоо гэдэг бол тодорхой нэг эрх ашгийн нэгдлийг хэлнэ. Тэр нь бүтээгдэхүүн дээрээ суурилж холбогдох юм уу, хорших юм уу, нэг эсвэл бэлчээр дээрээ суурилж хорших юм уу, холбогдох юм уу гээд. Ингээд тодорхой зорилготой хүмүүсийн нэгдлийг л хэлж байгаа юм. Түүнээс энд ингээд захиргааны аргаар бүгдийг нь нэгдсэн байдлаар анхдагч сумын холбоо, аймгийн холбоо ч гэж байх шиг. Тэгээд дээрээс нь тэд нарын нэгдсэн холбоо гээд. Одоо яг эрх зүй дээр гарч байгаа маш олон асуудлуудын гарцыг нь гаргаагүй. Хоршоо тэгээд нөгөө давхар хоршоо нийлсэн нэгдсэн хоршоо байгуулахад тэндээс гардаг татварын эрх зүйн маш том асуудлууд байдаг. Түүнийг удирдах бүс нутгуудын онцлогууд байдаг. Нэгдсэн байдлаар бүгдээрээ Монгол Улс орон даяар ийм холбоо байгуулаад тэрийг нь тодорхой хэмжээнд төр засаг оролцоотойгоор удирдах гэж байгаа бол энэ чинь нэгдэл болох гээд байна л даа. Хуучны социалист нийгмийн нэгдэл. Тэгээд ийм байдлаар нэгдсэн байдлаар бүх юмыг удирдаж чадах юм уу, болох юм уу, энэ чинь. Ийм л асуудал харагдаад байна.

Тэгээд та бүхэн маань яг юу бодож энэ нэгдсэн холбооны асуудлыг ярьж байгаа юм. Одоо яг байгуулагдвал ямар дүр зурагтай байгуулагдах юм. Мэдээж анхдагч холбоог 20-оос доошгүй өрх гээд заасан л байна л даа. Тэгээд энэ нь өөрөө бусад хоршоонд ороогүй хүмүүс нь энэ бэлчээрээ ашиглах эрх зүй нь яаж үүсэх юм гээд ийм олон асуудлууд энэ дотор байна. Тэгэхдээ яах вэ, зүгээр юмыг нөгөө нэг бүх юмыг шийднэ гээд ингээд асуудлыг ярьчихаар яг энэ хууль дотор нь тэр асуудлыг яг шийдэж байгаа гэдэг заалтууд байхгүй байна. Заалтууд нь байхгүй. Тэгэхээр нийгэмд маш том хүлээлт үүсгэчихсэн. Тэгээд нэг 5 их наядын хөтөлбөртэй зэрэгцүүлээд явж байгаа гээд бас зарим нэгэн Их Хурлын гишүүд улс төржөөд яриад байгаа. Тэгээд тэр энэ 2 нь яаж

холбогдож байгаа юм? Ийм асуултууд байна.

**Ж.Батжаргал:** Хариулъя. Ажлын хэсэг Лүндээжанцан 2 номер.

**Д.Лүндээжанцан:** Баярлалаа. Товчхон хариулахыг хичээе. Ер нь манайх 32 оны хамтрал комунаас хойш гучаад жил явж, мал сүрэг аятайхан өсөөд ингээд явж байгаад Нэгдэлжих хөдөлгөөн гэж 1959 онд улс даяараа захиргаадалтаар хийсэн, хамгийн сүүлд. Энэ нь бас нэг 30 гаруй жил яваад нэг тогооноос хооллож болдоггүй юм байна. Мал эзэндээ очих ёстой. Өмч эзэнгүйдсэн. Хүнийрхсэн. Болсон хүнийрхсэн. Ингээд нэгдэл тараах асуудал бол 91, 92 онд дамжиж яригдаж шүүхийн зарагтай ингээд ямар ч байсан мал эзэндээ очоод мал сүрэг өссөн. Хүмүүсийн аж амьдрал дээшилсэн, нөлөө үзүүлсэн.

Бас үүнээсээ хойш бас 30 хэдэн жил болчхож байгаа юм. Гэтэл одоо энэ амиа аргацаасан энэ мал аж ахуйн байдал ашиг шим нь буураад, бэлчээрийн 70 гаруй хувь нь талхлагдалд ороод манайх өргөн уудам газар нутагтайдаа л нэг өдий зэрэгтэй болж байна. Хэдэн жилийн дараа яах вэ, ийх вэ гэдэг харангын дохиог өгөөд энэ эрдэмтэд, судлаачид ингээд бүх юмыг нь газар зүй, нөгөө байгаль хамгааллын бүх эрдэмтэн судлаачид нь гаргачихжээ. Ингээд 30 хэдэн жилийн дараа нэгдлээр яваад 30 жил явлаа. Үр дүн гарсан, улс орны хэмжээнд бас мэдээж хэрэг сайр эерэг сөрөг олон юм байгаа. 30 хэдэн жил явлаа. Одоо яах вэ гэдэг асуудал тулгараад тэгээд энэ манай Улсын Их Хурлын гишүүд хөдөө орон нутагт уулзалт хийхэд түж энэ асуудал яригддаг юм байна. Бас хорших хоршооны хэлбэрийг хөгжүүлэе гээд бас их олон ажил зохиогдсон. Дундын хоршоо олон үүсгэл санаачилгууд байна. Хуулиуд гарсан. Нийтдээ энэ МАА-тай холбоотой яг тулж үйлчилж байгаа 13 хууль байна. Дээр нь 4 нэмэгдээд 17 хууль



байна. Эд нар амьдрал дээрээ яаж хэрэгжив гээд ингээд харахаар бас болж өгөхгүй нэг л юм дутаад байна. Энэ бол зохион байгуулалт дутаад байна. Хамтын зохион байгуулалт. Энэ нь хуучин нэгдэл биш. Энэ хоршоогоо ч амилуулах, цөмөөрөө эрсдэлээс хамгаалах, малынхаа ашиг шимийг нэмэгдүүлэх, тэгээд дээр нь малчдынхаа амьдралыг эрс сайжруулахад чиглэсэн ямар ч байсан тэр хамтын малчдын засаглал, хамтын менежментийн энэ зарчмыг нэвтрүүлэх нь зүйтэй гээд манай эрдэмтэд, судлаачид, академич Бакей Хөдөө аж ахуйн ШУА-ийн ерөнхийлөгч, ХААИС-ийн ректор Баасансүх гээд олон хүний судалгаанууд энд тодорхой судалгаанууд хийгдээд, энэ чиглэлээр түүх ... /минут дуусав/

**Ж.Батжаргал:** 2 номерын микрофоныг сунгая.

**Д.Лүндээжанцан:** Ингээд Улсын Их Хурлын дарга үүрэг өгөөд бид нэг 4, 5 сар ажиллалаа. Алийн болгон бодлого, хөтөлбөр, хууль ярих вэ. Энэ хуулиуд амьдрал дээр яг газар дээрээ бууж өгөхгүй байна. Ийм учраас тэр малчид нь нийлээд, зохион байгуулалтад ороод нэг ахлагч нар тавигдаад тэгээд явдаг. Тэр сум, аймаг, улсын хэмжээний нэгдсэн холбоо хүнд суртлын юм уу, хуучин Хөдөө аж ахуйн нэгдлийн дээд зөвлөл энэ тэр шиг байгууллага биш. Шал өөр. Харин төрд саналаа малчдынхаа саналыг л уламжилдаг ийм байгууллага байя гэдэг чиглэлээр ийм төслийг боловсруулсан. Одоо бидэнд үнэхээр цаг хугацаа бага байгаа учраас судалъя, үзье, харъя, дахиад сайн харъя гээд байх хугацаа үнэндээ байхгүй болчихжээ.

Тийм учраас нэг холбоон дээр яагаад хууль гарч байгаа юм бэ гэдэг асуулт гараад байгаа байхгүй юу. Тэгэхээр олон чиглэлийн энэ чиглэлийн ТББ ашгийн бус байгууллагын хуулиуд байна. Дээр нь түүгээрээ явж болохгүй байгаа энэ гарцаагүй малчдын 200 мянган малчин, 300-аад 200-аад малчин

өрх, 400-аад малчин нийтдээ сая гаруй хүмүүсийн асуудал байгаа учраас тулчихсан. Үүнийг ядахдаа хууль, эрх зүйн орчных нь хувьд бүрдүүлж, ач холбогдол өгч, хуулийн хэмжээнд зохицуулж өгөх ийм юутай хэрэгцээ шаардлага үнэхээр тулчихсан байгаа учраас бид цааш нь дахиж цаг алдах ямар ч аргагүй байдалд орчихоод энэ хуулийг оруулж ирж байгаа юм гэдгийг хэлэхийг хүсэж байна.

**Ж.Батжаргал:** Ганибал гишүүн дахин тодруулъя. Ганибал гишүүний микрофоныг өгөөрэй.

**Н.Ганибал:** Үгүй ээ, үгүй бүх юм болохгүй байгаа юм зөндөө л байна л даа. Тэгээд тэрийг энэ хуулиар зохицуулна гэж угаасаа байхгүй байх аа. Энэ чинь Монгол Улсад яагаад энэ хоршоо хөгжихгүй байгаа гэхээр тэр хоршоог удирдаад явдаг менежерүүд байхгүй байгаа байхгүй юу, 1 дүгээр асуудал нь.

2 дугаар асуудал нь энэ бүс нутаг болгон онцлогтой, өөр өөрийн онцлогтой, өөр өөрийн бүтээгдэхүүнтэй. Түүн дээрээ суурилсан, жишээлбэл Сүхбаатар аймаг, Баяндэлгэр улаан ямаа дээрээ суурилсан тэр үйлдвэрлэг байдал, цааш нь тэр бүтээгдэхүүнийхээ хамгийн үнэ цэнтэй болох тал дээр суурилсан ийм нэг зорилготой хүмүүсийн нэгдлийг л бий болгоно уу гэхээс ингээд хүчээр ингээд нэг байгуулчихаар тэгээд 1 холбоо байгуулчихаар бусад холбоо нь ямар ч өрсөлдөх чадваргүй болгоод тэгээд үүнийг төр удирдана гэж байгаа. Тэгээд энэ засаг дарга нар нь бүгдээрээ энэ холбоодын байгуулах бүх үйл ажил ... /минут дуусав/

**Ж.Батжаргал:** Ганибал гишүүний микрофоныг нэмээд өгчих дөө. Гүйцээгээд асуугаадахъя.

**Н.Ганибал:** Одоо сумын дарга сумын холбоог зохион байгуулна гэж байгаа. Анхны хурлыг нь зохион байгуулж даргыг нь томилж өгнө өө гээд. Аймгийн

холбоог болохоороо аймгийн засаг дарга томилно. Энэ аймгийн дарга, аймгийн Засаг, сумын дарга гэдэг чинь улс төрийн албан тушаалтай 4 жилийн цаг хугацаатай зөвхөн өөрсдийнхөө эрх ашгийн төлөө ажиллах хүмүүс байхгүй юу. Тэгэхээр энэ хүмүүс зохион байгуулсан холбоод тэр хүндээ л үйлчилнэ. Өнөөдөр бид нар бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Орон нутгийн амьдрал дээр хэн зохион байгуулаад хэнийгээ томилохоо бараг эхэлж тодруулчихаад тэгээд томилчихно. Тэгээд 1 бөөн маргаантай нэг ийм холбоо нэртэй яг эрх зүйн хувьд бас нэг айхтар том чадамж байхгүй. Үйл ажиллагааг нь сум, аймгийн Засаг дарга нар дэмжин ажиллана гээд биччихсэн. Энэ чинь ямар нэгэн дэмжлэг гэдэг нь өөрөө улс төрийн дэмжлэгээс өөр тэнд ямар дэмжлэг байгаа юм бэ?

Тэгээд ер нь зүгээр бид нар энэ түүхий эдийн тогтолцоо, энэ биржийнхээ үйл ажиллагааг сайжруулах, энэ зах зээлийн бодит зарчмууд руугаа явуулахгүй бол дээрээс нь ингээд ийм холбоо гээд бүр ингээд үймүүлээд, будилуулаад, ямар ч өмчгүй, хөрөнгөгүй, гэхдээ энэ хүмүүсээр дамжуулаад тухайн орон нутгийн бодлого явдаг нэг ийм хэлбэр лүү л орох гээд байна л даа. Тэгэхээр үүнийг л маш сайн тооцоолоод, хараад одоо ний нуугүй хэлэхэд энэ цаасан дотроос юу ч олж харахгүй. Энэ дотор та хэд яг ингээд загвар болоод энэ суман дээр ингээд хөгжүүлэх гэж байгаа гээд нэг ийм мэдээлэл байна уу? Үзүүлбэр байна уу? Презентэйшин байна уу. Тэрийгээ нэг танилцуулаач. Харья л даа хэдүүлээ. Үнэхээр бас болохгүй, болох гээд байгаа юмыг нь бид нар шүүмжлээд байгаа бол бас тэрийг нь харъя.

Хэрвээ зүгээр олон улсын тэр холбоодын асуудлаар адилхан гэж бодож хийсэн бол энэ буруу, тийм, энэ бол маш буруу. Тэд нар чинь тухайн бүтээгдэхүүн дээрээ суурилад холбоодоо байгуулдаг байхгүй юу. Түүнийхээ эрх ашгийг хамгаалдаг. Тэгэхээр энэ 2-ын хооронд

маш их зөрөөтэй ойлголтууд байна. Яг Монгол Улсад энэ яаж нутагших юм. Өнөөдрийн байгаа засаг захиргааны нэгжийн хажуугаар энэ холбоо яг яаж ажиллах гээд байгаа юм. 20 хүнтэй гээд би түрүүн хэллээ шүү дээ. Нэг баг дээр дунджаар 1 зуугаад өрх байна гэж бодъё, тийм ээ, малчин өрх. Тэрний 20 нь холбоо байгуулчихаад, 80 нь холбоонд ороогүй. Тэгээд тэр хүмүүсийн бэлчээрийн эрх зүйн асуудлыг энэ холбооны хуулиар зохицуулна гэх юм бол тэр гадна байгаа хүмүүс нь хаягдчихна. Үүнийг яаж шийдэх юм гээд ингээд асуудлууд нь яг ингээд бодит нөхцөл байдал дээр нэг сум дээр жишээ болгоод, нэг буулгаад нэг та хэд нэг яриад өгөөч.

**Ж.Батжаргал:** Хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

**Д.Лүндээжанцан:** Тэгэхээр Ганибал гишүүний санаа зовж байгаа зүйлүүд зөв өө. Яг бид нар энэ хуулийн төслийг эрдэмтэн судлаачидтайгаа, мэргэжилтнүүдтэй, хоршооныхонтой, ТББ-ынхантай, яам, Тамгын газрынхантай яриад сууж байхад асуудлууд яригдсан. Тэгээд яах вэ, одоо ингээд л яриад суугаад байх уу, хууль гаргах уу гэдэг асуудал яригдана. Тэгээд Улсын Их Хурлын дарга Занданшатар дарга үүнд хөдөө орон нутагт олон удаагийн уулзалт, дээр нь энэ эрдэмтэн судлаачдынхаа санаа бодол, судалгааны үр дүнгүүдийг судалж үзээд, бидэнд үүрэг өгсөн. Яг таны гарч байгаа ийм ийм асуудлууд үүснэ гэдгийг одоо цувуулж биччихэж байгаад тэгээд энэ дээр яах вэ гэдэг асуудлыг ярьсан юм.

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайлан гэж хүнс Хөдөө аж ахуйн яам, НҮБ энэ тэр гаргаад энэ биелээгүй гэж үзсэн. 17 оны байдлаар шүү дээ, тийм байх аа, 17 онд. Ингээд зөвлөмж дотор мөн л малчдын өөрийн засаглалын асуудал яригдсан. Ингээд бүс нутгийн онцлогуудыг яаж тусгах вэ? Говьд 20 айл гэдэг байна шүү

дээ, өрх айл гэдэг бол талын нэг тарчихсан л байгаа. Тал хээрийн нутагт юм уу, хангайн нутагт бол бараг цөөдөхөөр шахуу. Тэгэхээр энэ дотор жишээ нь Хэнтий аймгийн Баянмөнх суманд аравтын тогтолцоо гээд талийгаач болчихлоо. Би тэр хүний гэгээн дурсгалыг хүндэтгэж байна. Энэ хүн бол аравтын тогтолцоо хийхийн тулд 3 жилийн хугацаанд ухуулга, ойлголцож тэнд дургүй байж байгаад орсон хүмүүс хүртэл одоо бол тэнд малаа хамтарч ... /минут дуусав/

**Ж.Батжаргал:** 2 номерын микрофоныг сунгаадахъя.

**Д.Лүндээжанцан:** Энд бодитой ийм жишээ, туршлагауд сайн туршлагауд байна. Гэхээр ганцхан энэ дээр үндэслэж байгаа юм биш. Ямар ч байсан Монголд Аравтын тогтолцоо гэдэг тогтолцоо бол бүр Хүннүгээс эхлүүлээд 24 оны Үндсэн Хуульд хүртэл суугаад 10 гэр гээд сүүлдээ 20 болсон юм байна лээ. Энэ уламжлалт тогтолцоо бол одоо хэр нь үүнийг амь оруулаад шинэ зохион байгуулалтаар малчид хоорондоо хамтаръя. Тэгэхдээ өмч хөрөнгөөрөө биш ээ. Малынхаа ашиг шимийг дээшлүүлэх, өвчнөөс мал эмнэлгийн тарилга, туулга, угаалга гээд хүүхдийнхээ боловсрол, тэр малчдын холбоонд байгаа иргэдийнхээ эрүүл мэнд, энд нь хайя хүүе. Ядахдаа л малын хулгайгаас сэргийлэх гээд эргүүл гаргаад нэг 20, 30 айл сард нэг удаа ингээд явах. Үгүй ээ, шал өөр л болдог юм байна. Үүнийг хэрэгжүүлж байгаа газрууд бол.

Тийм учраас тэр бол хүнд суртлын байгууллагууд биш. Тэр сум, аймагтай яаж холбож өгсөн гэхээр нэг удаа анх зохион байгуулахад нь бас нэг оролцож, та нар мэд гээд бас орхичхож болохгүй. Анхных нь хурал цуглаанд нь л оролцъё гэж. Бусад ороогүй энэ чинь сайн дурын үндсэн дээр байгуулагдаж, бусад ороогүй нь яах юм бэ гэхээр одоо үүнийг энэ хуулийн дараагаар та нарын боловсруулж өргөн мэдүүлсэн Газрын

тухай хууль, тэр бэлчээр менежментийн асуудал тэнд гол нь хуулиар зохицуулагдана. Тийм учраас газрын реформ хоршоог хөгжүүлж одоо байгаагаас нь шат ахиулья гэх юм бол энэ нэг зохион байгуулалт, хамтын зохион байгуулалт үнэхээр дутагдаад байгаа юм байна аа гэдгийг л манай энэ судлаачид болоод малчид өөрсдөө, дээр нь Их Хурлын удирдлага энэ тэр олж харсан юм шиг байгаа юм. Тэгээд энэ дээр нь бид нар хууль хийж байгаа юм. Тэгээд гадаадын загвар манайд ер ... /минут дуусав/

**Ж.Батжаргал:** Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Өглөөний мэнд хүргэе. Энэ хуулийн төслийг бас уншиж үзлээ. Энэ хуулийн төсөл дээр шинэ харилцааг зохицуулсан, асуудал дэвшүүлсэн зүйл үнэндээ яг юу ч олж харсангүй л дээ. Энэ хоршооны хуулиас энэ Хөдөө аж ахуйн хоршооноос яг юугаараа өөр юм. Нэр нь холбоо гэж өөрчлөгдсөн байна. Ер нь өнгөрсөн зуунд бид нар, 100 жилийн хугацаанд хамтрал, коммун, нэгдэл хоршоо гээд энэ ийм малчдын холбоо гээд л нэг зүйл өөрчилж байгаа л юм харагдаж байна л даа. Ганц зүйл өөр болж. Тэр нь сумын дарга анхдагч хоршоодыг цуглуулж, хурал хуйг нь хийнэ гэнэ, аймгийн дарга бас хийнэ гэнэ. Тэгээд энэ чинь ганц өөр зүйл нь нэг захиргааны бас төвлөрүүлсэн нэг хуучны сум, нэгдлийн дарга гэдэг нэг ийм орон нутгийн бүтэц байсныг гаргаж ирэх гэж байгаа царай юм уу, бүү мэд. Тэгэхээр эндээс ер нь гол асуудал, гол асуулт нь өмнөх нэгдэл хоршоо яагаад амжилтгүй болоод байгаа юм бэ гэдэг дээр та нар яг тэр суурь асуултад ямар дүгнэлт хийгээд байгаа юм. Тэр суурь асуултдаа. Тэнд яагаад болохгүй байгаа, амжилтгүй болоод байгаа гэдэг тэр дүгнэлтээс ургаад энэ хууль дээр яг ямар зүйл заалт орсон юм. Тэрийг засаж залруулсан, тэрийг нь засаж залруулсан нь ямар зүйл заалт байгаа юм. Би лав эндээс тэрийг олж харсангүй. Нэг ийм нэрийн

хоршооны хууль дээр нэмэлт, өөрчлөлт ганц 2 өгүүлбэр оруулчихаар л юмыг л хууль болгоод л биччихсэн л ийм л зүйл л харагдаад байна л даа.

Ер нь хоршоо нэгдлийн маань үндсэн асуудал чинь явсаар эдийн засгийн асуудал чинь явсаар байгаад төвлөрлийг шаарддаг. Төвлөрлөөс чинь тийм ялгарал үүсдэг, мэргэшил үүсдэг. Тэгэхээр энэ зүйл маань л Монголын ХАА-д энэ нүүдлийн МАА 2 чинь огтлолцож өгөхгүй л үүний цаана асуудал яваад байгаа юм шиг л харагддаг. Төвлөрөл, төвлөрлөөсөө дагаад төрөлжилт бий болж байдаг. Төрөлжсөн эдийн засгаас чинь илүү ялгаатай бүтээгдэхүүн, чанартай бүтээгдэхүүн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн гарч байдаг. Тэгэхээр энэ энэ зэрэг ч юм уу, өөрөө тэр та нар суурь концептыг нь өнгөрсөн хугацааны бүтэлгүйтлийг юу гэж дүгнэсэн бэ? Эндээсээ яг энэ зүйл, заалт нь үүний эсрэг хариу урвал үзүүлж байгаа юм аа гэдэг тэр зүйлээ нэг тайлбарлаад өгөөч. Энэ дээр үнэхээр тэр зүйлийг олж харсангүй. Тэр сумын дарга л оролцохоор болчих гээд байгаа юм шиг л ганц өгүүлбэр л оруулж харлаа.

**Ж.Батжаргал:** Хариулъя. 2 номер.

**Д.Лүндээжанцан:** Би жоохон чанга яриад байх шиг байгаа юм аа, юмаа хүргэж чадахгүй байх шиг байна. Тэгэхээр энэ бол нэгдлийн тухай нэгдлийг, өнгөт үс зүсийг нь хувиргаж байгуулах гэж байгаа хууль биш. Тэр нэгдэл түүх болоод үлдчихсэн, тэндээ хоцорчихсон. Өнөөдөр амиа аргацаасан шинжтэй хот айлын зохион байгуулалттай яваа энэ манай нүүдлийн МАА эрхэлж байгаа энэ малчдынхаа мал сүргийг, амь амьжиргааг эрсдэлд оруулахгүй байхын тулд юу хийх ёстой вэ? Одоо хэдхэн жилийн дараа ус, бэлчээргүй болчих гээд байгааг яаж бид нар цааш нь хугацааг нь сунгаж, бэлчээр, усаа додомдох вэ гэдэг асуудал. Цэрэнпунцаг гишүүн эртээд ярьж

байсан. Тэр би яг энэ сонсож байсан. Завхан аймгийн Идэр суманд 25 ургамал ургадаг байсан чинь 20 нь байхгүй тийм үү? Одоо тавхан хүн төрлийн ургамал ургаж байна гэж. Манайх газар нутаг овоотой тулдаа л бид өвөг дээдсийн минь үлдээсэн юман дээрээ л ингээд нэг юм тэсэж байна шүү дээ. Одоо хэдхэн жилийн дараа байдал эвгүй болох гээд байна. Ийм учраас бид энэ малчин, мал, бэлчээр гурваа харилцан шүтэлцээнд нь авч үлдэх зорилт тулгарчхаад, тэгээд манай Их Хурлын гишүүд энэ дээрээ маш их ач холбогдол өгөөд 38 хүн гарын үсэг зураад, хуулийн төсөл өргөн барьсанд жирийн иргэн би маш их баярлаж байна.

2 дугаарт, манай их сургуулийн эрдэмтэн, докторууд Хөдөө аж ахуйн нэгдлийг, түүхийг судлаад алдаа оноог нь гаргаад бидэнд өгчихсөн байгаа. Дээр нь сүүлийн 30 жилд юун дээр нь алдав, юун дээр нь онов гэдэг судалгаанууд хийгдсэн. Одоо үүнийг би та нарт байна шүү дээ. Энэ манай Байнгын хороо өгчих байх тийм үү. Академич Бакей, доктор, профессор Баасансүх, Эрдэнэчулуун гээд олон докторуудын хийсэн судалгаанууд байж байна. Манай жишээ нь Бакей академи ч гэхэд сүүлийн бараг хориод жил байна шүү дээ. Нөгөө бид нар хамт индексжүүлсэн даатгалаас эхлээд л хамт явсан. Асар их судалгаанууд хийгдсэн. Үүнийг та бүхэндээ ингээд, судалгаанууд бол арвин хийгдсэн.

Дээр нь энэ хуулиуд Хоршооны хууль яагаад олигтой хэрэгжихгүй байна? Хоршоо чинь чиглэлээрээ байгуулагдаад байгаа байхгүй юу, саяынх шиг. Энэ бол Засаглал юм. Тэгэхдээ сумын даргын оролцоо гэж үндсэндээ байхгүй. Харин багийн даргатайгаа тэр багт байгаа нэг 5 ахлагч бол багийн даргатайгаа ганзага юу юу нийлээд, дөрөө харшуулаад л туугаад байна гэсэн үг. Тийм учраас тэр хөөрхөн зохион байгуулалтад нэг 20-оод айл нийлээд хөөрхөн зохион байгуулалтад орчхоод байгаа нь бас үр дүнгээ өгөөд эхэлчихсэн тийм зүйлүүд байгаа юм. Үгүй, үгүй

ядаж л хадлан тэжээл бэлтгэхдээ ганц ганцаараа явах биш бас нэг зохион байгуулалтад ороод явдаг. Малынхаа бууцны хөлд нэг тэжээлийн ургамал тарьчхаад нэг портер тэжээл авчихдаг ... /минут дуусав/

**Ж.Батжаргал:** Цогтгэрэл гишүүн тодруулъя.

**О.Цогтгэрэл:** Лүндээжанцан гуай, би зүгээр асуухдаа нэгдэл яг яагаад амжилтгүй болсон юм. Яг яагаад амжилтгүй болсон юм. Өнгөрсөн 30 жилд хоршоо яагаад амжилттай болохгүй байна вэ? Үүний суурь дүгнэлтийг та нар юу яг ямар дүгнэлтэд хүрээд, үүнийг зассан ямар заалт энэ хуульд байгаа юм бэ л гэж би асуугаад байна л даа. Магадгүй энэ хууль чинь ингэснээр энэ ХАА, МАА гэдгийг чинь санхүүгийн зах зээлийн нэг хэсэг энэ Монголын эдийн засгийн тогтолцооны, дэлхийн эдийн засгийн тогтолцооны нэг хэсэг болгож яаж холбож өгөх юм? Энэ дээр яг ямар зүйл заалтууд орж байгаа юм бэ? Тэр чинь харагдахгүй байна.

Хамгийн гол нь дахиад асуухад өмнөх нэгдэл, өмнөх социализмын үеийн нэгдэл өнгөрсөн 30 жилийн хоршоо амжилтгүй болж байгаа үндсэн шалтгаанд ямар онош тавьсан юм? Та болохоор нэг ийм ач холбогдлыг нь яриад хэрэгцээ шаардлагыг нь яриад байна л даа. Бүгдээрээ л мэдэж байна. Яг өвчиндөө бид нар онош тавьчхаад эмчилгээгээ хийнэ биз дээ. Тэгэхээр онош энэ дээр харагдахгүй байгаад байна. Түүний эмчилгээний санал энэ дээр байх ... /минут дуусав/

**Ж.Батжаргал:** Товчхон хариулна шүү. 2 номер.

**Д.Лүндээжанцан:** Нийтийн тогооноос хооллох нь боломжгүй гэдгийг Хөдөө аж ахуйн нэгдэл харуулсан. Нэг тогооноос. Бүр зарим газар жишээ нь энэ манай урд хөрш энэ тэр чинь бүр нэг тогоо, жинхэнээсээ нэг тогоо, газар

ухаж байгаад бүр хүртэл яасан байгаа шүү дээ, энэ чинь. Тэгээд тэрийг задлах гэж хэчнээн юм болсон. 78, 9 оноос эхлээд л хэчнээн юм болсон. Ингээд 80-аад онд эрчээ аваад айл айлдаа газар нутгаа хувааж өгөөд, ингээд бэлчээрээ хуваагаад өгчихсөн чинь ямаа үржүүлээд тэгээд бас нэг 20-оод жил их ашигтай явж байгаад одоо бас яах вэ гээд ингээд тулчихсан байгаа юм. Энэ чинь бас гаднын турилага гээд яривал бас зөндөө юм байна. Тэгэхээр бид болохоор байна шүү дээ, Хөдөө аж ахуйн нэгдэл бол өөрсдийнх нь өмч биш байсан учраас нэг 75 толгой мал, 50 толгой мал гэж байсан учраас хүний юман дээр нийтийн тогоонд чинь бүтэхгүй байна шүү дээ. Ийм учраас өмч эзэндээ хүрсэн. Хөдөө аж ахуйн нэгдэл бол тэр түүх болоод үлдсэн.

Бид дараа нь мал эзэндээ очоод өссөн, дээшилсэн, дэвжсэн. Гэхдээ өнөөдөр 30 хэдэн жил явчихсан чинь бас тэнд хамтын зохион байгуулалт ямар нэг байдлаар бага ч гэсэн үгүйлэгдэж байгаа юм байна. Энэнээсээ болоод хоршоо ч олигтой явж өгдөггүй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ ч олигтой явж өгдөггүй, шинжлэх ухаан, технологи нэвтэрч чаддаггүй, аягүй олон юм байгаа учраас энэ дотор тэгээд, тэгээд гээд тэр 9 дүгээр зүйл, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйлээр бид хийж өгсөн. Хамгийн наад зах нь л түүхий эд бэлтгэлийн тогтолцоог малын амьсгаанаас бусдыг нь 100 хувь ашиглах энэ зорилтыг л хамгийн наад зах нь хэрэгжүүлэх. Тэгээд дээр нь кластериар хөгжүүлэхтэй холбоотой Хөдөө аж ахуйн бирж өөрсдийнх нь байгуулсан тэр дундын хоршоо сумдаа байдаг юм уу ... /минут дуусав/

**Ж.Батжаргал:** Цогтгэрэл. Хариулна. Би тэртээ тэргүй хариулах гээд байж байна.

**О.Цогтгэрэл:** Саяын хариултуудыг үнэхээр хэтэрхий ерөнхий, зүгээр л хэтэрхий зүгээр л нэг ийм хуульч

хүний тайлбар ч юм уу, ийм байгаад байна л даа. Эндээс ямар нэгэн эдийн засгийн утга учир энэ хоршоо яагаад амжилтгүй болсон гэдэг олон зүйл ерөөсөө сонсогдохгүй байгаад байна. Энэ хууль санаачилсан гишүүд нь хариулт өгөөч. Энэ яг эдийн засгийн утга, тэр менежментийн утга яг юунаас болоод энэ өнгөрсөн социализмын үеийн нэгдэл, шинэ 30 жилийн хоршоо яваагүй юм. Одоо энд яг ямар засвар, өөрчлөлт энэ хуулиар хийх гээд байгаа юм? Яг юу өөрчлөгдөх гээд байгаа юм. Аль өгүүлбэрт нь байгаа юм, тэр утга нь.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр хэдүүлээ амьдарсан амьдралынхаа түүхийг үечилж харах тухай л асуудал байна. Нэгдлийг би их муу зүйл байсан гэж боддоггүй шүү, яг үнэнийг хэлэхэд. Ер нь энэ нүүдлийн мал аж ахуйн зохион байгуулалтын их том дээд хэлбэр байсан. Нэгдэл яагаад тарсан. Бид нар ардчилал, зах зээлийн харилцаа руу шилжсэн. 2 талаасаа нөхцөл байдал үүссэн. Бид түрээсийн гэрээ гэдэг үйл явцыг нэвтрүүлсэн юм. Тийм учраас мал маллаж байсан малчид маань өөрийнх нь хувийн мал, эзлэх хувийн жин нэмэгдчихсэн байхгүй юу. Тийм учраас засгийн гэдэг юм уу, тэр хоршоолсон ардын данстай малыг өгчих нь зөв юм байна, өөрийнхөө хөрөнгөөр явчихъя гэсэн оюун санаа малчдад нь буучихсан. Нэг.

Нөгөө талд нь нэгдлийн гишүүд чинь бас дан ганц малчид байгаагүй юм. Тухайн орон нутгийн иргэд нь байсан юм. Тэд нар бид өмчтэйгөө больё гэдэг үйл явц явчихсан юм. Энэ хоёр 2 талаасаа ирж уулзаад нэгдэл их амархан тарсан. Гэхдээ бид төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаар явж байсан. Эдийн засгийн арга талд маань асуудал байсан уу гэвэл байсан. Түүнийг засаад цаашаагаа явбал ер нь өнөөдрийн энэ хүндрэлүүдээс учиргүй нүүр тулчихгүй явчих тийм бололцоо байсан байхыг үгүйсгэхгүй гэж боддог. Энэ бол түүх.

30 жил яаж явав аа, шинэ цагийн 30 жил яаж явав. Яг нарийндаа байгалийн даац чадамж энэ нөөцийг шавхаж ашиглаад, малаа өсгөсөн. Түүнийгээ хөрөнгө гэж ойлгосон. Эдийн засгийн эргэлтэд оруулдаг арга хэлбэр нь дутсан. Улсын өөрийнх нь анхдагч үйлдвэрлэлийнхээ үйлдвэрлэлийг боловсруулах шатынх нь үйлдвэрлэлийн хурдац гүйцэж чадаагүйгээс болоод бүтээгдэхүүн ашиг шимийнх нь үнэ цэн олигтой өсөж өгөөгүй юм. Үүнээс болоод энэ асуудал чинь нэлээн төвөгтэй байгаа юм.

3 дахь зүйл юунд байсан. Энэ өөрөө эргэх 4 цаг, эрс тэс уур амьсгал. Тийм учраас амьдралынх нь хэв маяг ийм учраас наадах чинь байгалийн хараат аж ахуй. Гэтэл уур амьсгал өөрчлөгдөөд байгалийн эрсдэлтэйгээ давагдашгүй хүчин зүйлүүдийн давтамж их ойртчихлоо. Байгалийн даац чадамжаасаа хэтэрсэн үйл явцуудыг бид явуулаад байна. Үүнээс болоод цөлжилт үүслээ, 70 гаруй хувь нь цөлжчихсэн. Яг энэ хэвээрээ явах юм бол цаашаа байдал дордох нь ээ. Маши яаралтай арга хэмжээ авах юм бол 80 хувь нь байгалийнхаа жамаар сэргээж болох нь гээд манай эрдэмтдийн хийчихсэн тов тодорхой судалгаанд байгаа юм.

Энэ хуулиар бид юу зохицуулах гээд байгаа юм гэж. Энэ хуулиар анхдагч харилцааг нь зохицуулах гэж байгаа юм. Энэ нэг тархай бутархай, үгүй үгүй амиа хичээсэн энэ аж ахуйн чинь, байхгүй ээ. Хоршоо үндсэндээ ашгийн төлөө үйл явц. Бүтээгдэхүүн дээр чиглэсэн юм яваад байгаа. Энэ бол мал аж ахуйн үгүй үгүй энэ. Түүнийг нь салгах хэрэгтэй байна. Мал аж ахуйн үйлдвэрлэл гэдэг бол байгальтайгаа харьцсан үйл явц юм байна. Тэгвэл наад, тэгвэл хэдүүлээ яана гэж ойлгох юм, Цогтгэрэл ээ. Энэ олон зуун жил өвгөдийнхөө бий болгосон энэ өв соёлоо хагас сууринаар дамжаад суурин, мал ажиллагаа руу явах юм уу? Үгүй, үгүй. Би асуултад хариулж байна. Та байж бай л даа. Би таныг асуулт

асуухад юм яриагүй шиг санах юм. Хэдүүлээ уул нь бас хэдэн биедээ жоохон хүлээцтэй хандчихвал яасан юм бэ дээ?

Тэгэхээр ерөөсөө энэ аж ахуй өөрөө бэлчээр дээр гол үйл явц нь явдаг юм байна. Тэгвэл энэ тулчхаад байгаа асуудлыг нь зохицуулахад хамгийн түрүүн анхааръя. Энэ бэлчээр нутгийнхаа менежментийг зөв болгоё гэдэг юм байна.

2 дугаарт, бэлчээр дээр ирдэг ачааллыг бууруулахад нэгжээс авдаг ашиг шимээ нэмэгдүүлдэг юм байна. Тийм учраас малынхаа үйлдвэр ашиг шимийг нэмэх, эрүүлжүүлэх тухай асуудал байх юм байна гэж.

3 дугаарт нь, энэ бүтээгдэхүүнээ хэдүүлээ зах зээлд нийлүүлэх, барих бүх юмыг нь өөрсдийнх нь тэр үүсгэл санаачилгын ашгийн төлөө байгууллагаар нь явуулъя. Гэхдээ түүндээ төвлөрүүлж чиглүүлэх үйл явцыг нь үүгээр нь анхдагчийг нь хийж өгье. Ингэснээрээ бид хоршоо хөгжүүлэх түлхцийг нь бий болгож байгаа юм л гэж ингэж л харж үзэл санаагаа хийсэн. Тэгсэн байх аа.

Хоршооны хууль энэ 2-ыг зэрэгцүүлээд уншвал арай өөр юм уншигдана. Нэг нь зохион байгуулалтын чиглэлтэй юм яригдана. Нэг нь аж ахуй, ашгийн төлөө юм яригдана.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хуулийн төсөлтэй холбогдуулж, танилцуулгатай холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу? Нэрээ өгчих. Цэрэнпунцаг гишүүнээр, Дамдинням гишүүнээр тасаллаа.

Тэмүүлэн гишүүн саналаа хэлье.

**Г.Тэмүүлэн:** Тэгэхээр энэ хуулийн төслийг бас санаачилсан хууль санаачлагчдын нэг нь бас би өөрөө

байгаа. Тэгэхээр яг үндсэндээ яах вэ, энэ малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулиас гадна бид нар ер нь яах вэ, зүгээр мал аж ахуйн салбар дээр ер нь томоохон бодлогын болоод хандлагын өөрчлөлтийг зайлшгүй гаргах шаардлагатай байгаад байгаа. Тэгэхээр энэ хаврын чуулган нэг талдаа бид нарын бас өнгөрсөн 20 жилийн хугацаанд үүссэн засаглал тогтолцоотой холбоотой, нөгөө тал дээрээ бодлого болоод хандлагатай холбоотой бүх асуудлууд дээр бас нэг үнэлэлт дүгнэлт хийж хууль, эрх зүйн орчин талаас нь хууль тогтоогчийн хувиар Улсын Их Хурал бодлогын болоод хандлагын өөрчлөлтийг гаргах энэ түүхэн цаг хугацаа байна л гэж харж байгаа. Энэ хуулиас нэмж давхар бас хувь хүнийхээ үүднээс яг цэвэр энэ малчны эрх зүйн байдлыг тодорхойлох анхдагч хууль болсон суурь харилцааг зохицуулах бас малчны тухай, малчны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг тун удахгүй бас энэ 7 хоногтоо эцэслээд Улсын Их Хурлын даргад өргөн барьж, ирэх 7 хоногоос хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй байна. Тэгэхээр манай байнгын хорооны гишүүдийг ч гэсэн та бүхнийг бас хамтарч энэ дээр бас оролцоосой гэж хүсэж байгаа.

Нөгөө талдаа бид нарын хувьд энэ малчны ажиллах, амьдрах, дээрээс нь мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэрлэл эрхлэх, мал аж ахуйн тэр таатай нөхцөлийг нь бид нарын хувьд бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Нөгөө талдаа энэ байгальд ээлтэй болоод бүтээмжтэй эрсдэлгүй МАА-г хөгжүүлэх нь үндсэндээ Монгол Улсын тэргүүн зорилго болоод байна аа л гэдэг энэ асуудал байгаа юм. Тэгэхээр ерөөсөө малчны тухай Үндсэн хуулийн маань гол концепт бас энэ дээр байгаад байгаа. Одоо орж ирж байгаа энэ хууль маань бол цэвэр малчдын хамтарч, нэгдэж, нийлж, хоришиж үйл ажиллагаагаа, үйлдвэрлэлээ, нөгөө талдаа адаглаад бэлчээр ашиглах харилцаа нь ч тэр, тухайн тэр нүүдэл суудал хийгчдэд ч

тэр, хөдөлмөрөө хорших ёстой ч тэр, мал сүргээ маллахдаа ч тэр, хамтарч, нэгдэж, нийлж, хоршиж одоо юу гэдэг юм үйл ажиллагаагаа явуулах суурь харилцааг зохицуулж байгаа энэ асуудлууд байгаад байгаа юм.

Үндсэндээ бид нар яг суурь бид нарын асуугаад байгаа, яриад байгаа, анхаарал хандуулаад байгаа зүйл маань энэ ерөөсөө малчны бүтээмжийг бид нар яаж дэмжих вэ л гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр ерөөсөө малчны бүтээмжид нөлөөлж байгаа үндсэн 5, 6 хүчин зүйлс буюу элементүүд байна.

1 дүгээрт, малчны боловсролтой холбоотой асуудлууд байна. Төр засаг энэ дээр зайлиггүй анхаарах ёстой. Насан туршийн боловсролыг бий болгох зайлиггүй шаардлага байна.

2 дугаарт, энэ малын генетик нөөц болоод эрүүл мэндийн тухай хуулиар заасан малын эрүүл мэнд, үржил селекцийн ажилтай холбоотой асуудлуудыг бид нар цаг хугацаа технологийнх нь хугацаанд зайлиггүй хийдэг болох шаардлага байна. Үүнийг бас тодорхой хэмжээнд хариуцлагажуулах шаардлага байна.

3 дугаарт, энэ малын арчилгаа, маллагаатай холбоотой асуудлууд дээр ч гэсэн бид нар зохистой дадлыг бий болгож тухайн хүн маань өөрөө бас хэрхэн хариуцлага хүлээх вэ, төр энэ дээр хэрхэн дэмжих вэ, туслалцаа үзүүлэх вэ гэдэг асуудлууд байна.

4 дүгээр үндсэн суурь асуудал бол бид нар мал аж ахуйн салбарыг тэжээлийн хангамжаас нь салгах боломж бололцоо байхгүй. Тэгэхээр энэ дээр өөрчлөлт оруулж, энэ тухайн тэр Газрын тухай хууль дээр малчин айл өрх өөр өөрсдийнхөө өвөлжсөө, хаваржаан дээр ядаж 1 га газраа нэг малынхаа тэжээл тариалдаг. Малчид баг багийнхаа хурлын түвшиндээ шийдвэр гаргаад багийнхаа хэрэгцээний энэ ган,

зуд, эрсдэлтэй нөхцөлд ч гэсэн багийнхаа хэмжээнд даван туулах тэр тэжээл хангамжийн асуудлыг өөрсдөө шийддэг, малчин өрх өөрсдөө шийддэг, баг өөрөө шийддэг, сум аймаг өөрсдөө шийддэг болох энэ тогтолцоог хийх шаардлагатай байгаад байгаа. Тэгээд Ганибал гишүүн бид хэд ч гэсэн бас хамтдаа энэ хуулийн төслийг өргөчихсөн. Энэ Байнгын хороо энэ хуулийн төслийг бас энэ хавартаа амжаад тэр дундаа энэ ган, зуд нүүрлэсэн энэ цаг үе дээр бид нар энэ том бас бэлчээртэй холбоотой, тэжээл тариалахтай холбоотой, Газрын тухай хуультай холбоотой асуудлууд дээр ч гэсэн том бодлого, хандлагын өөрчлөлтийг гаргах зайлиггүй шаардлага байна гэж харж байгаа.

Бид нарын хувьд бас анзаардаггүй байсан, анхаардаггүй байсан зүйл бол энэ мал аж ахуйн салбарын энэ хашаа хороотой холбоотой асуудлууд байна. Мал аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчлөх шинэ арга технологийг нэвтрүүлэх асуудлууд байна. Тэгэхээр ерөөсөө цогцоор нь бид нар энэ зүйлүүдийг төрөөс онцгой анхаарч, дэмжиж, хөгжүүлж, малчин болон салбарын үйл ажиллагаа үр ашгийг нэмэгдүүлэх боломж бололцоо бүрдэх л асуудлууд байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр хамтдаа цогцоороо бүгдээрээ бас нэг эрх зүйн орчныг нь бүрдүүлэх тал дээр нь, засаглал тогтолцоог бий болгох тал дээр нь, энэ бодлогын хандлага болоод өөрчлөлтийг бий болгох тал дээр нь, өнгөрсөн алдаа онооны хийдэл завхрал болоод тухайн тэр алдааг засаж залруулах дээр бас нэг хамтарч ажиллах зайлиггүй шаардлага байна гэж харж байгаа.

Мөн дээрээс нэг зүйлийг бас мэдээлэл болгоод Байнгын хорооны гишүүд хэлэхэд бол малчин болоод хувиараа бизнес эрхлэгчдийн НДШ-ийг нөхөн төлүүлэх тухай хуулийг бид нар 21 онд санаачлаад бас өргөн бариад батлуулж байсан. Тухайн үедээ ковидын цар тахалтай цаг үед малчид болоод



хувиараа бизнес эрхлэгчид дөнгөж аравхан хувь нь хамрагдаж байсан. Хатуу хөл хорионы 5, 6 сарын хугацаанд ямар нэг амьжиргаа орлого байгаагүй, хуулийг таниулан сурталчлах ажлууд хийгдээгүй. Тэгэхээр энэ хуулийг ч гэсэн бас энэ 7 хоногтоо өргөн бариад энэ нийгмийн баталгааг нь хангах зүйл дээр хамтраад ажиллая гэсэн ийм санаачилгатай байгаа.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Мөнхцэцэг гишүүн.

**Г.Мөнхцэцэг:** Нэгдэл гэнэ үү, хоршоо гэнэ үү ямар ч байсан энэ хөдөө аж ахуйн салбарт хийж байсан менежмент тухайн цаг үеийнхээ үүргийг гүйцэтгээд ирсэн л гэж би бас ингэж боддог. Энэ Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль өөрөө үндсэндээ бас яг энэ цаг үеийн энэ хөдөө аж ахуйн салбарт бий болсон олон олон асуудлуудыг бас шийдэхийн тулд ингэж гарч ирж байгаа ийм хууль гэж бас дэмжиж байгаа.

Дээр нь энэ зүгээр нэг хэн хэдэн хүн зохиогоод ингээд биччихсэн биш ялангуяа малчдаасаа малчин өрхүүд өрхүүдээсээ гарсан санал санаачилгууд хийгээд бас тэнд болж байгаа асуудлуудыг ингэж бас томъёолж оруулж ирсэн ийм том хууль гэж бас ингэж бодож ойлгож байгаа юм. Ер нь зүгээр хуультай ч байна уу, хуульгүй ч байна уу энэ өөрөө тэр үйл явдлууд нь тэртээ тэртэй тэр хөдөө орон нутаг хөрсөн дээрээ болж байгаа л үйл явдлууд байхгүй юу. Жишээлбэл ингээд Дундговь аймгийн олон сайхан залуучууд нийлээд л өрхөөрөө нийлээд л ер нь бид нар бас ингээд сум сумдаас нийлээд л нэг асуудлаа шийдэхийн тулд энэ өрхийн холбоогоор хоршиж ажилладаг ийм менежмент рүү явъя аа гээд л ингээд л ажиллаад л явж байгаа жишээнүүд зөндөө олон л байж байгаа байхгүй юу. Тэгэхээр эд нарыг нэгтгээд энэ хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлээд өгөх юм бол

өнөөдөр бас энэ биелээд ингээд явчих ийм хууль гэж ингэж ойлгож байгаа.

Мэдээж ажлын хэсэг гараад явах байх. Тэр ажлын хэсэг энэ зүйлүүдээ бас тусгаад ингээд явчих байх гэж бодож байгаа.

Тэгээд дээр нь би түрүүн цаглавар батлахад байж байгаагүй учраас нэг зүйлийг энэ манай Байнгын хороо маань өөрөө зөвхөн хөдөө аж ахуйн салбарын асуудлуудыг ингээд хэлэлцээд байдаг Байнгын хороо биш. Байгаль орчин гэж тусдаа том энэ чинь яамтай, том салбар байж байгаа. Энэ яамны гэдэг юм уу энэ салбарын эрх зүйн зохицуулалттай хуулиуд яагаад орж ирэхгүй байгаа юм бэ? Тухайн болоод тэр Усны тухай хууль хэчнээн жил дарагдав. 4 жил доош хэртэй боллоо шүү дээ. Тэгээд ерөөсөө явуулдаггүй тийм, ингээд байгаад бариад байгаад байдаг. Гэтэл өнөөдөр уг нь энэ хууль чинь нэн тэргүүнд шаардлагатай байгаад байна шүү дээ. Ялангуяа энэ говийн нөхцөлд энэ уур уурхайтай холбоотой, ундны устай холбоотой энэ асуудлууд нь байгаад байхад яагаад энэ зохицуулалтуудыг нь хийх энэ хууль юмнуудаа оруулж ирэхгүй байгаад байгаа юм бэ. Байгаль орчны яамыг 3, 4 жил л хүлээж байна шүү дээ. Энэ хууль ерөөсөө орж ирэхгүй байна. Тийм, ажлын хэсгээ ч ерөөсөө ажиллуулдаггүй.

Тусгай хамгаалалттай газар нутгуудын тухай хууль хааччихав. Энэ хуулиуд чинь өнөөдөр хэрэгтэй байгаад байна шүү дээ. Тэгэхээр ер нь энэ цаглавар батлахад би энэ саналуудыг хэлье гэж бодож байсан юм. Тэгээд энэ хууль дээр ч гэсэн энэ Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль дээр ч гэсэн Байгаль орчны яамыг бас татан оролцуулах хэрэгтэй. Бэлчээрийн тухай юмнууд асуудлууд байж байна. Ундны ус, ингээд энэ чинь хоршоод холбоод ингээд ажиллах зөндөө олон асуудлууд байгаад байгаа учраас энэ Байгаль орчны яамыг нэг сонсвол яасан юм бэ? Тэгээд энэ хуультай холбоотойгоор хийгээд зарим

орж ирэх ёстой байсан хуулиудтай холбоотойгоор ойрын хугацаанд энэ асуудлуудыг нь бас авч хэлэлцэх ийм саналуудыг бас оруулаач гэдэг ийм хүсэлт байсан юм. Тэгээд энэ саналыг бас хэлье.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.  
Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Үгүй ээ, гол нь асуудал шийдээд юмны ард гарч байвал болно. Түүнээс ингээд нэг ийм лоозогносон байдалтай, ганцхан концепцтой, холбоо байгуулахад сумын дарга хурлыг нь зохион байгуулаад байгуулж өгнө. Аймгийн холбоог байгуулахад аймгийн Засаг дарга байгуулж өгнө гээд нэг ийм л өгүүлбэр л энэ дотор байна. Бусад нь дандаа л нөгөө байдаг өнөөдрийн хоршооны тухай эвлэлдэн нэгдэх бүх асуудал байж байна. Дээрээс нь Малын генетик нөөцийн тухай хууль, өнөөдрийн мөрдөж байгаа тэр Газрын тухай хуульд байгаа хэдэн заалтууд л байж байна шүү дээ. Өнөөдрийн тэр хадлангийн талбай гэдгийг газрын нэгдмэл санд орсон талбай л гэж байна. Өнөөдөр энэ болгон чинь болохгүй л байгаа байхгүй юу. Өнөөдөр та бүхэн ногоон тэжээл тарина. Зөвхөн тэр өвөлжөө бууцанд тарина гээд. Үгүй тэр чинь болохгүй л байна шүү дээ. Болдог байсан бол энэ саяын энэ хуульд заавал бичээд хийгээд яваад шаардлага байгаа юм уу. Одоо яагаад тэр Бэлчээрийн тухай хуулиа оруулж ирэхгүй байгаа юм. Бие даасан хууль. Яагаад тэрийг заавал ингээд Газрын тухай хуульд нэгдэж оруулж ирээд бүтэн 30 жил ер нь, 20 жил ямар нэгэн асуудлыг ар дээр нь гаргаж шийдэх тийм эр зориг бид нарт байхгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд ийм гөлгөр, ямар ч асуудал шийдэхгүй, зөвхөн пи арын шинжтэй, малчдынхаа төлөө нэг ийм холбоо байгуулж өгөх гэж байгаа, хууль байгуулж өгөх гэж байгаа гэсэн нийгэмд ойлголт өгсөн ийм хуулиар бид нар яах юм бэ. Юмныхаа ард гаръя л даа.

Өнөөдөр та бүхэн энэ малчид чинь юун хориороо хорших биш хот айлаараа амьдарч чадахгүй болчихоод байна шүү дээ. Ах дүү нар хоорондоо мууддаг болсон. Зохицуулалтууд нь байхгүй. Энэ чинь өөрөө бодит амьдрал дээр ийм байгаа юмыг бид нар заавал тэр хүчээр аваачиж 20 хориороо нийлүүлээд байгуулна аа гээд ингээд хүчлэх гээд байна шүү дээ. Өнөөдөр бид нар малчдын нөгөө түүхий эд бараа бүтээгдэхүүний үнийг нь өсгөнө гээд бүх намууд сонгууль болгондоо амлаад ордог, өсгөсөн үү? Уг нь адууны мах гарч байсан, дулааны аргаар мах гардаг, бүгдийг нь хорьдог. Тэгээд нөгөө бизнесийг нь бүр ингээд зогсоодог. Тэгээд нөгөө худалдан авах тал нь Монголын энэ зах зээлийн энэ арилжаанд орж байгаа байдалд итгэхээ байсан. Бид нараас юм авахыг хэн ч хүсэхээ байсан. Зөвхөн Улаанбаатар хотын суурин газрынхаа хэрэглээний зөвхөн дотоодын хэрэглээнийхээ тэр зах зээлийг бид нар өөрсдийнхөө бодит зах зээл гээд хардаг. Түүндээ тааруулсан бодлогууд хийдэг. Тэр арьс ширний нөгөө үйлдвэрүүд хаана байна. Үүний чинь гол хамгийн том проблем нь тэр цэвэрлэх байгууламжууд. Тэгээд Дархан хотод цэвэрлэх байгууламж барья гэсэн улс төрийн учир шалтгаан юм уу, ямар шалтгаан юм. Нэгийг барьж байхад нэг хажууд нь эргээд шинээр барина гээд ажиллаад эхэлчихсэн ч байх шиг. Өнөөдрийн төрийн барьж байгаа бодлогууд биднийг алаад байгаа байхгүй юу.

Одоо 24 оны 07 сарын 01-нээс эхлээд зөвхөн угаагаад самнасан ноолуур гаргана аа гэдэг шийдвэр гарсан. Ирэх жилийн ноолуурын үнэ ямар байхыг мэдэхгүй байна. Энэ жил өнөөдөр ямааны арьс яагаад 40, 50 мянгаас илүү гарахгүй байгаа юм бэ. Энэ чинь 1 кг ноолууртай эр ямааны арьс 50 мянган төгрөг гэдэг чинь ямар зах зээл юм бэ. Уг нь ноолуурыг нь самнасан бол тэр чинь 1кг ноолуур чинь өнөөдрийн зах зээл дээр 160 мянган төгрөг хүрэх ёстой ямааны арьс шүү дээ. Тэрийг чинь тэр угаасан

ломаз гэдэг бүтээгдэхүүнийг гарахыг хориглосон шийдвэр гарсан учраас өнөөдөр тэр бүтээгдэхүүний үнэ ийм доошоо орчихсон л байхгүй юу. Тэгэхээр энэ техникийн олон зохицуулалтууд өнөөдрийн энэ урт хугацааны малчидтай таарсан тэр бодлогуудыг хуульчилж өгмөөр байна. Тэгвэл энэ өнөөдөр энэ үйлдвэрлэл чинь хөгжинө, малчид чинь энэ тогтвортой бүтээгдэхүүний үнэтэй болно. Түүнээс нэг нөхөр гарч ирэнгүүтээ нэг шийдвэр гаргангуутаа бүх юмных нь үнийг нь ингээд тастаад тастаад хаячихдаг. Тэгээд тэрийгээ буцаагаад сэргээж чаддаггүй. Ийм л 30 жилийг өнгөрөөсөн шүү дээ. Үгүй ээ, тэр зохицуулалт өнөөдөр бэлч яагаад мал өсөөд байгаа юм. Хамгийн том суурь шалтгаан чинь мал нь үнэ цэнгүй байгаа учраас тэнд олныг өсгөж байгаад өөрийнхөө амьжиргаанд хүргэх гээд л хүмүүс тэмцээд байгаа шүү дээ. Энэ чинь хүн болгон өөрийн гэсэн эрх чөлөө, хувийн өмчийнхөө тэр төлөө, өөрсдийнхөө орлогыг нэмэгдүүлэхийн төлөө л энэ нийгмийг бид нар байгуулсан шүү дээ. Түүнээс өнөөдрийн энэ лоозон шиг энэ хууль хийгээд энэ бүх асуудлыг шийднэ гэвэл энэ өнөөдрийн байгуулсан нийгмийнхээ эсрэг бид нар хууль барьчихсан гээд өнөөдөр хэлэлцээд явж байна шүү дээ. Үгүй ээ, тэр 37 гишүүд энэ асуудал дээрээ ард иргэдээ ... /минут дуусав/

**Ж.Батжаргал:** Баярлалаа.  
Ганболд гишүүн.

**Г.Ганболд:** Ганибал аа, ер нь жаахан хэдүүлээ логик дараалалтай явах ёстой шүү дээ. Эхлээд мэдээллээ ав, мэдээллээ ав, мэдээллээ ав. Өнөөдөр байна шүү дээ, ямааны ноолуур 172 мянга байна. Наадах чинь бид нарын тэр дотооддоо бүгдийг нь самнаж угаах шийдвэр гаргасны үр дүн шүү. Тэгж байж энэ дотооддоо суурилуулагдсан хүчин чадал чинь 10 мянган тонн ноолуураа угаах хүчин чадал чинь энэ Монголд суурилагдчихаад байна. Хилийн цаана угаадаг байсан бол өнөөдөр

Эмээлт зах дээр 1 кг ноолуур 172 мянган төгрөгөөр авч байна. Ямааны би ноолуур ярьж байна, арьс яриагүй байна. Чи байна шүү дээ, эхлээд сонс доо. Хэдүүлээ ингээд үүнийг. Эхлээд байна шүү дээ, чи байна шүү дээ. Энэ холбоо барихад, холбоо байгуулахад чи юунд нь эсэргүүцээд байгаа юм бэ? Өнөөдөр Монгол Улсад 200-аад мянган малчин өрх байна. Эд нарын эрх ашгийг хамгаалж байгаа хүн хэн байгаа юм, хэн байгаа юм, эрх ашгийг нь хамгаалж байгаа хүн хэн байгаа юм.

**Ж.Батжаргал:** Ганибал аа, чи яамны газрын дарга байхад арьс унасан шүү.

**Г.Ганибал:** Одоо байна шүү дээ, эрх ашгийг нь хамгаалж байгаа хүн хэн ч байхгүй. Гэтэл ингээд хоршоодын холбоо гээд бүхэл бүтэн байшинтай, өчнөөн олон хүмүүсийг. Үгүй ээ, хамгийн гол нь ингэх гээд байхгүй юу, хэн ээ. Одоо бид нар байна шүү дээ. Энэ олон мянган малчдын ...

**Ж.Батжаргал:** Ганболд гишүүн үгээ дуусгаадах даа, саналаа хэлье.

**Г.Ганболд:** Үгүй ээ, үүнийг эсэргүүцээд байхыг нь би гайхаад байх юм. Энэ заавал байгуул гэсэн үг биш шүү дээ. Байгуулахгүй ч байж болно. Тухайн бүс нутгийн багийн иргэд нь өөрсдөө нэгдээд л тэгээд л байгуулбал тэр л биз. Үгүй ээ байгуулахгүй бол тэр л биз дээ, энэ чинь. Уг нь гол санаа нь ерөөсөө энэ малчдын эрх ашгийг хамгаалдаг холбоо гэж байхгүй. Тэгээд 1 ганц нэг улс төрчид нэг янз бүрийн нэртэй холбоо байгуулчихсан. Тэгээд нөгөөдөх нь ингээд яриад явахаар нь улс төр болчихдог.

Ингээд саяын Ганибал гишүүн шиг ингээд л Сүхбаатар аймаг хүнд байна, малчид баларлаа л гээд байгаа байхгүй юу. Улс төрч ярихаар чинь ингээд энэ чинь улс төр болоод дэмжлэг явахгүй шүү дээ. Тэгэхээр энэ холбоо байгуулаад, сум болгоноо холбоо байгуулаад сумдынх

нь аймгийнхаа холбоог үүсгээд, аймгууд нь энэ чинь улсын холбоо үүсгээд явах юм бол энэ чинь эрх ашгийн төлөө, малчдынхаа эрх ашгийг яаж хамгаалах вэ, энэ малчид руу чиглэсэн төрийн бодлогыг яаж хандуулах вэ гэдэг чинь нэг улс төрийн зорилгогүй өөрсдөө байгуулсан ийм холбоодоороо дамжуулаад явах нь үр дүнтэй байгааг ингээд хоршоодын холбоо гээд л том байшин савтай тэгээд л хоршоодынхоо лоббиг хийж явсаар байгаад л хөдөө бүх сумдын нэг Сум хөгжлийн сан зээл өгдөг байсан, тийм ээ. Иргэн болгонд өгдөг байсан энэ чинь лобби хийсээр байгаад зөвхөн хоршоонд өгдөг болгочихсон шүү дээ. Одоо зөвхөн хоршоод л зээл авна. Гэх мэтчилэнгээр үүнийг ингээд заавал харлуулах шаардлага байхгүй.

Дэмжээд, тэгээд энэ боломжуудыг нь хангаад, тэгээд энэ чинь явцын дунд шаардлагатай бол дахиад энэ хуулийн төслүүдэд чинь өөрчлөлт оруулаад улам эрх зүйн байдлыг нь дээрдүүлээд, үйл ажиллагааг нь тэлээд, явцын дунд чинь амьдрал баян, сая энэ нэг дөрөвхөн сэдвээсээ халиад явах юм байж болно шүү дээ. Тэгэх юм бол үүнийг чинь илүү сайжруулаад л ингээд л явахад татгалзаад байх зүйл байхгүй.

Тийм учраас бид нар санаачилсан. Тэгээд орж ирж байгаа юмнууд ч тэгээд дандаа нэг тийм улс төрийн зорилготой болчихсон, чадлын эсэргүүцэх гэсэн ийм агуулгатай л байгаад байна л даа. Тийм учраас хуулийг явуулах нь зүйтэй гэж дэмжиж байна.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.  
Цэрэнпунцаг гишүүн.

**Ц.Цэрэнпунцаг:** Эсэргүүцээд байсан гишүүд маань гараад явчихсан, би яг дэмжиж хэлэх гээд байгаа юм. Энэ уул нь бид нар энэ хуулийг бид нар нь яг цаад агуулга, ямар үзэл баримтлал, онолд үндэслэж ийм хууль гаргах шаардлагатай байгаа юм гэхээр зэрэг нэг

эрдэмтэн Нобелийн шагналттай нэг *Остром* гээд нэг эрдэмтэн эмэгтэй бараг анхны эдийн засаг ч биш улс төрийн шинжлэх ухааны эрдэмтэн байгаа байх энэ чинь. Энэ эмэгтэй ингээд энэ судлаад энэ нөөц, нийтийн энэ өмчийг үүний өмнөх ойлголт нь юу байсан гэхээр зэрэг нийтийн эзэмшлийн өнөө гамшиг гэдэг үг нэр томъёо гарчихсан. Энэ нийтийн ингээд манай бэлчээр шиг ийм юмыг ингээд ашиглаад ингээд дуусдаг. Үүнийг бол ерөөсөө эсвэл хувьд шилжүүлэх ёстой. Эсвэл ерөөсөө тэр газрыг ашиглахыг хориглох гээд энэ тусгай хамгаалалттай газар болгодог юм уу. Ийм арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх ёстой гээд ийм үзэл дээд талаас нь л ер нь нөгөө хууль гаргаад л ингээд л босоогоор шийдчих ёстой, хориглох тэр бэлчээрийг хамгаалах ийм жишигээлбэл бэлчээр дээр ийм арга хэмжээнүүд авах ёстой гэдэг ийм үзэл онол яваад байсан бол энэ эмэгтэй үзээд үгүй юм байна. Энэ нутгийн иргэд чинь өөрсдөө энэ нөөцөө ашиглахдаа маш ухаалаг дүрэм, журмыг манайхаар бол ёс заншил, харилцаа тогтоочихдог юм байна. Тэр нь өөрөө энэ буцаад нөөцөө зөв ашиглах, ингээд урт удаан хугацаандаа энэ нөгөө тогтвортой ашиглах ийм бололцоо үүсгэчихдэг юм байна гээд. Одоо загасчид дээр жишигээлбэл. Загасчид яадаг вэ гэхээр зэрэг бид нар далай шиг их юм байхгүй загас бол тоо тоймгүй юм байдаг гэж бодож явдаг. Тийм биш юм байна тэр чинь загасчид тэр ойрхон завиа хүрдэг ойрхон газарт тавивал загас нь байхгүй, загасанд хэн түрүүлж гарсан нь хамаад л дуусдаг. Краб гээд нэг юмыг барьдаг хүмүүс бол тэгээд 1 ийм доошоо тор тавьж байгаад авдаг. Бас тэрэнд чинь түрүүлж тавьсан нь л дуусгачихдаг байсныг. Очоод тэд нар дээр судалгаа хийгээд, тэгээд 1 Непал ч билүү газар тариалан эрхэлж байгаа жижиг ийм улсууд хүртэл усныхаа нөөцийг яаж ашиглаж байгаа юм гэсэн чинь тэр хүмүүс иргэд өөрсдөө ингээд хоорондоо яг ашиглаж байгаа яг нутгийн иргэд маань одоо энэ дээр бол малчид маань

өөрсдөө ингээд цуглаад тэр хоорондоо ингээд албан ёсоор ингээд 1 ерөнхий ингээд нэг баг 5 ийм юу болох билээ, энэ чинь, өрхийн ийм холбоо биз дээ, тийм малчин өрхүүдийн ийм нэгдсэн холбоо ийм нэгдээд ажиллах ийм бололцоог нь олгоод өгөх юм бол энэ хэд өөрсдөө санаачилга гаргаад, бид нарын мал ингээд энэ жил бэлчээрээ ингэж ашиглавал ингэх юм байна.

Ийм учраас цөмөөрөө хоорондоо дүрэм хийгээд нэг нэг дээрээ хяналт тавьдаг нь аягүй сайн. Жишээлбэл үүний дээрээс бид нар нэг хууль гаргах юм бол ямар ч сайн хууль гаргаад хэрэгжихэд хэцүү байхгүй юу. Тэр малчид чинь хэдэн малтай байгааг нь тоолж өдөр болгон хянаж тэр нь ашиглах ёстой бэлчээрээ цаг улирлынхаа дагуу ашиглаж байгаа юм уу хянах арга байдаггүй. Тэгтэл энэ нутгийн иргэд чинь өөрсдөө дүрмээ гаргаххаараа өөрсдөө хяналтаа тавиад явчихдаг ийм үр ашигтай явдаг юм байна аа гэдгийг нь энэ судлаад, туршаад ингээд нотлоод энэ дээр үндэслээд энэ маш олон улс орон бол энэ нийтийнхээ энэ хэрэгцээнд байдаг энэ манай бэлчээр шиг энэ зүйлээ ашиглахдаа энэ арга хандлага дээр бодлогоо гаргаж ажилладаг юм байна.

Тэгэхээр бид нарын энэ өнөөдрийн энэ хууль яг энэ бодлого дээр үндэслэж нутгийнх нь малчин иргэд өөрсдөө тэр бэлчээрээ менежментийг нь хийж ашиглах тэр боломжийг нь нээж өгөөд гаргаж өгч байгаа л байхгүй юу. Түүнээс манай эсэргүүцээд байгаа гишүүд болохоор зэрэг л шууд хатуу хууль гараад л дээрээс хуулиуд гаргаад л ингээд л шийдэл байх ёстой энэ дунд чигээр хатуу юм хараад байдаг зүйл заалтууд. Тэгтэл энэ яг энэ хуулийн зорилго нь өөрөө тийм учраас яг ийм байх ёстой. Малчидтай ерөөсөө л бид нар нийлээд л нэгдээд л малчин өрхүүдийнхээ холбоог байгуулаад л бэлчээрээ яаж ашиглах вэ. Энэ жил алийгаа нөөцөд авах юм. Энэ бүх ажлуудаа хоорондоо шийдээд явчихдаг, хоорондоо хамгийн гол нь хяналт

тавьдаг. Өнөөдөр бид нарт хамгийн гол өнөөдөр төрийн үйл ажиллагаа хууль гаргаад, хууль хэрэгждэггүй нэг аюултай юм бид нар хуулийн хэрэгжилтэд хяналт төр тавьж чаддаггүй, хуулиа хэрэгжүүлдэггүй.

Тэгэхээр энэ хууль ингээд энэ гарах юм бол малчид өөрсдөө өөрсдийгөө хянаад хэрэгжүүлээд явчихдаг учраас хамгийн үр дүнтэй байна аа л гэж байгаа юм. Тийм учраас бид нар энэ ажлын хэсгээ гаргаад энэ эсэргүүцээд байгаа гишүүддээ үүнийг нь ойлгуулаад, энэ одоо АН-ынхан маань шинэ соргог зах зээлийн тэгээд л бас арай төрийн захиргааны аргаар шийдлүүдийг л хэрэглэх ёстой л гээд л яриад байдаг шүү дээ. Тэгээд яг энэ аргыг нь хэрэглэж байгаа энэ хандлага энэ бодлогыг нь тэгээд үндэслэж энэ гаргаж ирж байгаа энэ хуулийн төслийг эсэргүүцээд байдаг нь би буруу байна аа л гэж бодож байгаа юм. Тэгээд дэмжиж байна, энэ хуулийн төслийг.

**Ж.Батжаргал:** Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Бас хууль санаачлагч гишүүдийн нэг. Тэр яах вэ, манай зарим гишүүд бас ойлголт муу байгаа, бас бичиг цаасаа хараагүй байгаа учраас эсэргүүцээд байх шиг байна. Энэ хуулийн үндсэн санаа нь үндсэндээ энэ зуд, гангийн бэрхшээлтэй нөхцөл байдлаас Монголын энэ хүн амын тал нь амьдарч байгаа орон нутагт байгаа энэ малчин, уламжлалт болон фермерийн МАА-г эрхэлж байгаа малчин өрхүүдээ бас нэг гаргаад авъя. Туслах суурийг нь бий болгоё. Хууль, эрх зүйн орчныг нь тодорхой болгочихё. Ингэж хууль, эрх зүйн орчныг нь тодорхой болгох үндсэн санаа нь юунд байгаа вэ гэхээр бид нар зуд болохтой зэрэг л энэ хүмүүст тусламж өгөхөөс өөрөөр ямар ч дэмжлэг байдаггүй.

Энэ хүмүүсийн өмчийг барьцаалдаг газар нь үндсэндээ ганцхан банкнууд байна, арилжааны банкнууд байна. Асар өндөр хүүтэйгээр барьцаанд оруулчихсан байж байдаг. Хөнгөлөлттэй зээл, тусламж авах боломжгүй. Нийтээрээ нэгдээд татварын хөнгөлөлт урамшуулал авах боломжгүй. Нийтээрээ нэгдээд хүүхдүүдээ онлайн сургалт авах эсвэл бизнесийн ямар нэг сургалт авах, нийгмийн бусад үйлчилгээг авах, ядаж л малаа нэг онлайнаар дижиталаар ингээд энд давуу талын шилжилтээр тоолуулчихдаг энэ боломж нөхцөлийн эрх зүйн орчин нь байхгүй байхгүй юу.

Тэгээд улс даяараа бид нар, дижитал шилжилт гээд л Цахим хөгжлийн яам байгуулаад л ингээд үзэж тараад байдаг. Малчдад зориулсан юм тэнд гарах ёстой шүү дээ. Мал тооллого гээд л жил болгон бид нар маш олон хүнийг тал тал тийш нь явуулдаг. Тэгэхээр үүнийг онлайнаар хийчих бололцоотой энэ эрх зүйн зохицуулалтыг нь хийгээд өгчихье. Хүүхдүүдийг нь цахимаар сургадаг энэ боломж нөхцөлийг нь хүмүүс хоршоогоороо дамжуулаад авдаг байлгая. Нийгмийн үйлчилгээгээ энэ хуулийнхаа тэр хоршоогоороо дамжуулаад авдаг байлгая гэдэг ийм л зохицуулалтыг хийх гэж байгаа шүү дээ.

Төрөөс хөнгөлөлттэй зээл олгоё, төрөөс эх үүсвэрийг нь гаргаад банкнуудаар дамжуулаад энэ малчдад өөрсдөдөө зориулсан махны үйлдвэр байгуулах, эсвэл малчид өөрийнхөө малын эрүүл ахуй халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахиулах эсвэл одоо хажуудаа тэр жижиг аж ахуй бий болгоод ногоон тэжээлээ тарьдаг больё, тэрийгээ үйлдвэрлэдэг больё гэдэг энэ зохицуулалтыг нь бид нар энэ хуулиар хийж өгөх гэж байгаа юм.

Энэ суурь хуулийг бид нар хийж өгснөөр дараа нь ямар асуудлууд үүсэж гарч ирэх вэ гэхээр малчдын хоршоотой хамтарч ажилладаг компаниуд орж ирэх ёстой болчихно. Ингэж байж энэ үйл

ажиллагаа амжилтад хүрнэ. Түүрүү манай гишүүд асуугаад байна лээ. Энд ямар ялгаа байгаа юм. Яаж амжилтад хүрэх гээд байгаа юм гээд.

Махны үйлдвэрүүд нь холбоодтой энэ хоршоотой ажиллаж эхэлнэ. Махны үйлдвэрүүдэд нь зээлийн эх үүсвэрийг нь өгөөд, махны үйлдвэрүүд нь тэр малчдаа сургаад, малынх нь үржил шимийг нь сайжруулаад, вакцин халдваргүй аюулгүй байдлыг нь хангах тал дээр нь туслаад зөвлөөд явдаг энэ эрх зүйн орчин, суурь нь энэ Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль дээр яваад байгаа юм. Түүнээс биш бид нар тийм нэг сонгуульд зориулсан ч гэдэг юм уу, лоозонгийн ч гэдэг юм уу урианы зориулалттай ийм хууль бол хийгээгүй. Ингэж байж бид нар энэ зуд турхан, ган, энэ аюулт байдал, байгаль орчны энэ хүнд байдлаас гарах хэрэгтэй.

2 дугаарт, бид нар нөгөө талд нь бас малчин өрхүүдээ энэ хариуцлагажуулах асуудлыг энэ хууль дээр тусгаж байгаа. Малчин өрхүүд сүргийн бүтцээ зөв зохион байгуулдаг болох, малынхаа сэг зэмийг устгадаг байх, бэлчээрээ хамгаалдаг байх энэ үүрэг, хариуцлагыг бид нар малчин хүн хийж байвал хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулна, татварын хөнгөлөлт үзүүлнэ, илүү боломжийг олгоно гэдэг энэ зохицуулалтыг л энэ хуулиар хийж өгөх гэж байгаа. Тэгэхээр бид нар энэ хуулиа бас зөв ойлгоод, үнэхээр бас асуудалтай гэж үзээд байгаа юм байгаа юм бол үүнийгээ бас ажлын хэсэг дээрээ бид нар ярилцаад хэлэлцээд явах нь зүйтэй.

Төрөөс малчдад ямар дэмжлэг үзүүлдэг вэ. Өнгөрсөн ковидын жилүүдэд бид нар нэг нийгмийн даатгалынх нь 50-ийг нь төрөөс даая гэдэг асуудлыг бөөн шүүмжлэл дундуур явуулж байгаад л хийсэн. Тэгээд зуд болохтой зэрэг нэг 5 кг будаа, 10 кг будаанаас өөр юу гурилаас өөрөөр бид нар нэг туслаад байгаа юм байхгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр бизнесжүүлбэ, бизнесийнх нь орчныг нь бүрдүүлбэ. Хувийн хэвилийнхэн орж ирэхэд малчид маань бэлэн болчихсон байх, зохион байгуулалтад орчихсон байх, эрх зүй нь тодорхой байх энэ орчныг угтаад бий болгоё гэдэг ийм л хууль юм байгаа юм. Тэгэхээр энэ хуулийг бас дэмжих ёстой. Бас нийгэмд зөв ойлгуулах ёстой л гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Энэ хуулийн төсөл дээр ганц нэгхэн зүйл тодруулах ёстой юм болов уу гэж би ойлгоод байна. Тэгэхдээ улсууд маань нэлээд нь гараад явчихлаа. Амьдралын хийгээд нийгмийн зайлиггүй шаардлага дээр тулгуурлаад энэ хууль гараад ирлээ л дээ. Боловсруулах зайлиггүй шаардлага үүсээд.

Дээр нь малчдын хамтын менежментийг л төлөвшүүлэх тухай асуудал эрх ашгийг нь хамгаалах тухай л асуудал байгаад байгаа юм. Үүгээрээ дамжуулж. Тэгээд уг эрхэлж байгаа аж ахуй маань өөрөө байгальтайгаа салиггүй холбоотой ийм аж ахуй учраас байгалийнхаа даац, чадамжтай нийцэх тухай л ойлголт байгаад байгаа юм. Тэгээд бид нарын ерөөсөө өвөг дээдсийн маань баримталж ирсэн гол зарчим юу байсан бэ гэхээр айл айлын амь нэг, саахалт айлын санаа нэг гэдэг энэ язгуур хамтынх нь үйл ажиллагааны оюун санаан дээр тулгуурласан л үйл явц байхгүй юу. Тэгэхээр энэ нь энэ хуульдаа тусаж орлоо. Үүний гол суурь нь эндээ бий боллоо л гэж л ингэж л ойлгосон.

Мэдээж энэ хуулийг би төгс болчихсон гэж ойлгохгүй байна. Хэлэлцэх эсэхээ дэмжбэ хэдүүлээ. Ажлын хэсгээ гаргая. Тал бүрээсээ ярилцбэ, сайжруулах ёстой юм байгаа бол сайжруулбэ. Энэ өөрөө анхдагч хууль. Тийм учраас илүү сайжруулах бололцоо боломж нь ямарваа нэгэн хууль, эрх зүйгээр

хязгаарлагдахгүй. Тэгээд үүгээрээ сайжруулбэ.

Дан ганц энэ хуулиар бүх харилцааг бас зохицуулж чадахгүй. Тийм учраас хууль хоорондын давхцал гэдэг юм уу, хийдэл гаргахгүйн үүднээс энэ хуульд оруулмаар санагдаад байсан зүйлүүд өөр хуулиуддаа тодотгож орж байгаа. Жишээ нь Газрынхаа тухай хуульд ч гэдэг юм уу, малын тоо толгой, албан татварын тухай хуульдаа ч гэдэг юм уу ингэж л орж байгаа. Тэгээд одоо бид нар юм ярихаараа их цогцоор нь харах гээд байдаг.

Манай энэ хуулийн чиглэлийнхэн, эрх зүйчид маань харахаараа зэрэг хууль зүйн техник талаасаа асуудалдаа хандаад, эрх зүйн хүртсэн соёл түвшинээс ухарсан юм болох гэж байна наадах чинь, ингэж зохицуулдаг юм гэдэг юм яриад. Гэхдээ би ямар ч байсан бодож байсан бодлууд, дагасан хууль хийгээд үндсэн энэ өргөн баригдсан хууль хоёртоо шингэчихлээ л гэсэн л ийм л ойлголттой байгаа. Сайжруулах зүйлүүд байгаа гэдэгт бас ойлгож байна.

Ингээд гишүүд үг хэлж дууссан тул Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжбэ гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулбэ. Санал хураалт.

66,7 хувиар дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Мөнхцэцэг гишүүн танилцуулбэ.

Ажлын хэсгийнхээ хамт олонд баярлалаа.

Өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирж оролцсон гишүүддээ баярлалаа.

*Ингээд Байнгын хорооны  
өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудал  
дууссан тул Байнгын хорооны  
хуралдааныг өндөрлүүлж байна.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*П.ОЮУНГЭРЭЛ*